



Монгол улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ ба нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалт

Монгол Улсын Засгийн газар (“Засгийн газар” гэх) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын гадаадаас авах ажилтны хувь хэмжээг жил бүр шинэчлэн тогтоодог билээ. Монгол улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг Засгийн Газар 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 360 тоот тогтоолоор (“Засгийн газрын 360-р тогтоол” гэх) шинэчлэн тогтоолоо. Мөн өдрийн 359 тоот тогтоолоор (“Засгийн газрын 359-р тогтоол” гэх) Монгол улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг баталсан.

Холбоо барих:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батчулууны Амаржаргал

Хуулийн үйлчилгээний менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
amarjargal.batchuluun@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn



Хураангуй



2022 оны 7 дугаар сарын 1-ий өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (“АХШХТХ”) -ийн 22 дугаар зүйлийн 22.1-д зааснаар Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар жил бүрийн 10 дугаар сарын 01-ий дотор Засгийн газар тогтоохоор заасан. Үүний дагуу Засгийн газрын 360-р тогтоолд эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааран 2024 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо хэмжээг тогтоосон.

Энэхүү Засгийн газрын 360-р тогтоолд зааснаар эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тогтоосон Монгол улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо нь 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Монгол улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааран мэдээлэл, холбооны салбарт 60, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт 10, барилгын салбарт 5000 ба уул уурхай олборлох салбарт 10000 зэргээр 10-10000 хүртэлх ялгаатай тоогоор нийт 27851 тооны гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохоор тогтоосон байна.



АХШХТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.5-д зааснаар нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хоёр жил тутамд 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар батлахаар заасан. Ийнхүү Засгийн газрын 359-р тогтоолд зааснаар эдийн засгийн үйл ажиллагааны салбарын 11 ангилалд, 130 нарийн мэргэшлийн ажлын байрны нэрсийг харгалзах Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08 (YAMAT-08) индексийг зааж, шаардагдах мэргэжлийн түвшнийг тогтоосон байна. Шаардагдах мэргэжлийн түвшнийг дараах байдлаар ангилсан байна:

- 01 Мэргэжлийн тусгай болон түүнээс дээш;
- 02 Бакалавр болон түүнээс дээш; ба
- 03 Магистр болон түүнээс дээш.

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН-өөс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2023 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН-г илэрхийлнэ.





Юу өөрчлөгдсөн бэ?

Бид 2024 онд дараах салбаруудад тогтоосон гадаад ажилтны тоо болон нийт гадаад ажилтны тоонд эзлэх хувийг 2023 оныхтой харьцуулан онцолж байна.

Салбар	Тодорхойлолт	Гадаад ажилтны тоо	Нийт гадаад ажилтны тоонд эзлэх хувь	Гадаад ажилтны тоо	Нийт гадаад ажилтны тоонд эзлэх хувь
		2023		2024	
A	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	108	0.53%	250	0.90%
B	Уул уурхай, олборлолт	8000	39.31%	10000	35.91%
C	Боловсруулах үйлдвэрлэл	984	4.84%	1500	5.39%
D	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1511	7.42%	1361	4.89%
F	Барилга	3644	17.91%	5000	17.95%
G	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	2118	10.41%	3300	11.85%
H	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	1642	8.07%	2100	7.54%
K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	41	0.20%	70	0.25%
L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3	0.01%	10	0.04%
N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	248	1.22%	300	1.08%
P	Боловсрол	980	4.82%	1500	5.39%
U	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	96	0.47%	150	0.54%

Өмнөх онтой харьцуулахад 2024 онд олгох нийт гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тоо 7500-аар өссөн ба дараах салбаруудад харьцангуй өндөр өсөлт ажиглагдаж байна. Үүнд, уул уурхай, олборлолтын салбарт 8000-аас 10000, боловсруулах үйлдвэрлэл 984-өөс 1500, барилгын салбарт 3644-өөс 5000, мэдээлэл, холбооны салбарт 2-оос 60, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт 8-аас 150, боловсролын салбарт 980-аас 1500, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт 15-аас 150, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын хувьд 178-аас 700 зэргээр гадаад ажилтны тоо, хувь хэмжээ өссөн байна. Нөгөөтэйгүүр, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын хувьд 2023 онд 1511 байсан бол 2024 онд 1361 гадаад ажилтан байхаар бууруулсан байна.



Энэхүү мэдээлэлтэй холбоотой нэмж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах линкнээс авна уу: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16959991321161>

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960002897981>



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2023 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.